

ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН АНГИЛАЛ ДАХЬ ЧАВХДАСТ ЦОХИВОР ЁОЧИНГ ШИНЖЛЭХ НЬ

Самдансүрэнгийн Уранбилэг*, Ц.Цэвэгсүрэн

*Үндэсний урлагийн тэнхим, Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль,
Улаанбаатар, Монгол Улс*

*Э-мэйл: huiia_4@yahoo.com
ORCID: 0009-0008-2914-8945

Хүлээн авсан 2023.12.20

Засварласан 2024.03.02

Хэвлэлтэд 2024.04.24

Хураангуй

НТӨ VI зуунаас НТ XX зуун хүртэх хөгжмийн ангиллын системд тулгуурлан чавхдаст цохиворын төрлүүдийг шинжих нь олон улсын зэмсэг судлал (*organology*)-ын түвшин дэх ёочингийн байр суурь, төлөв байдал, төрөл зүйлсийг тордуулахад ач холбогдолтой юм.

Зэмсэг судлалын түүхэнд хөгжмийн зэмсгийг урт хугацааны турш газарзүйн болон гарал үүсэл, уламжлал, хийц бүтэц, хөгжимдөх үйлээр нь олон янзаар ангилж ирсэн бөгөөд ерөнхийлсөн байдлаас үзэхэд “чавхдаст”, “үлээвэр”, “цохивор” хэмээх гурван төрөл түгээмэл байдалтай байна.

Энэхүү уламжлалт гурван ангиллыг түүхийн явцад хөгжим судлаачид, онолчид олон янзаар нарийвчлан системчилж илүү боловсронгуй болгон хөгжүүлж ирснээс XIX зууны үеийн Австрийн угсаатны хөгжим судлаач Хорнбостел (*Erich von Hornbostel*), Германы хөгжим судлаач Сакс (*Curt Sachs*) нарын тоон систем (*ziffersystem*)-д индексжүүлэн кодолсон “Хорнбостел-Саксын систем” (*Hornbostel-Sachs sistem*)-ийг бид онцгойлон авч үзэж байна.

Энэхүү системд чавхдастын төрлийг хэлбэр дүрс, эгшиглээний онцлогоор *lyre*, *lute*, *harp*, *zither* хэмээн дөрөв ангилахдаа аливаа нэгэн зүйлээр чавхдасыг цохин хөгжимдөх зэмсгийг хийц бүтэц, физик шинж чанар, хөгжимдөх үйлээр нь тус тус дөрөв ангилж “*zither*”-ийн төрөлд хамруулжээ.

Дээрх судалгаанаас үзэхэд, “ёочин” нь “zither”-ийн ангилал дахь “bar”, “tube”, “raft”, “board”, “Trough”, “frame” зэрэг зургаан төрлийн зэмсгүүдээс “board “zither” буюу чавхдасыг цохин хөгжимдөх үйлийн, хөндийлөн угсарсан хавтгай хэлбэрийн ангилалд хамрагддаг байна.

Түлхүүр үг: Зэмсэг, ангилал, төрөл зүйл, уламжлал, шинэчлэл, хэлбэр, хийц бүтэц, чавхдас



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)

Оршил

Монгол үндэстний соёл сэтгэлгээ, уран сайхны тусгал болсон хөгжмийн урлаг тэр дундаа үндэсний гэх өвөрмөц онцлог бүхий хөгжмийн зэмсгүүд нь эрт үеэс уламжлагдах явцдаа баялаг түүхийг бүтээсээр ирсэн.

Тухайлбал: Манай үндэсний хөгжмийн урлагт онцгой байр суурьтай өвөрмөц нэгэн зэмсэг бол “ёочин” юм. Энэ нь Монголын хөгжмийн урлагт олдмол уламжлалаар уламжлагдаж ирсэн бөгөөд зэмсэг судлалын түвшинд үүнийг “чавхдаст цохивор” хэмээн ерөнхийлөн тодорхойлдог.

Ёочин, ёочиндох урлагийг хойч үедээ уламжлан өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлийн нэгэн чухал хүчин бол шинжлэх ухааны ач холбогдолтой судалгаа шинжилгээ юм. Иймээс бид энэ удаа ёочинг олон улсын зэмсэг судлалын түвшинд, хөгжмийн зэмсгийн ангилал хүрээнд авч үзэв.

Чавхдаст цохивор төрлийн зэмсэг нь энэхүү системийн түүхийн эхэн үед (*II зуун*) цохиворын төрөлд ангилалддаг байсан ч цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдсөөр XIX зууны эхэн үеэс “Хорнбостел-Саксийн систем”-ийн “Ziffernsystem” буюу “Тоон систем”-д индексжин, хэлбэр дүрс, чавхдасны тоо ширхэг, эгшиглээний онцлог, хөгжимдөх үйлээрээ хордофон (*chordophone*)-ийн төрөлд хамрагдах болсон юм [1]. Бид ёочин төст олон арван зэмсгийг энэхүү ангилалд хэрхэн ангилсан төлөв байдлыг нарийвчлан судалсан судлагдахууныг өөрийн орны зэмсэг судлалын түвшин дэх судалгааны эргэлтэд оруулах нь чухал ач холбогдолтой юм. Судалгааны ажлын зорилго бол, ёочинг, олон улсын зэмсэг судлалын түвшинд судалж ангилал, төрөл зүйлийг тодруулахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- ✓ Чавхдаст зэмсгийн ангилал, төрөл зүйлийг хөгжмийн ангиллын системд тулгуурлан мөшгөн шинжих;
- ✓ Чавхдастын ангилал дахь ёочингийн байр суурь, төлөв байдал, төрөл зүйлийг судлах

Хэрэгцээ шаардлага: Монголд үндэсний хөгжмийн зэмсэг судлалын судалгаа өнөөгийн байдлаар эхлэл төдий байна. Зарим судлаачдын тэмдэглэснээр шударга, лимбэ, морин хуур, ятгыг эс тооцвол бусад зэмсгүүдийн хувьд дорвитой, тодорхой түвшинд судлагдаагүй хэмээн тодотгодог.

Ёочин нь манай үндэсний уламжлалт зэмсэг бөгөөд түүний гарал үүсэл, тархац нутаг, ангилал, төрөл зүйлс, хийц бүтэц, хөгжимдөх үйл нь Монголын хөгжмийн зэмсэг судлалын түвшинд (*зөвхөн дотоодод*) ерөнхийлөн дурдсан байдалтай ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, эмхэтгэл, илтгэл, бүтээлүүдээс хэтрэхгүй байна.

Мөн олон улсын зэмсэг судлалын түвшин дэх ёочингийн язгуур уламжлал, ангилал, төрөл зүйлс, төлөв байдал, байр суурь, уламжлал, шинэчлэл манай үндэсний хөгжмийн судлагдахуунд өнөө хэр асуулт хэвээр байна.

Иймээс энэхүү судлагдахууны чухал хэсэг болох ангилал, төрөл зүйлсийг өргөн хүрээнд мөшгөн судалж судалгааны эргэлтэд оруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй бидний өмнө тулгараад байна.

Дэвшүүлж буй асуудал бол, хэрэгцээ шаардлагын хүрээн дэх судалгааны үр дүн нь ёочингийн судалгааны хамрах хүрээг тэлэх, энэ чиглэлийн судлаачдад чиг баримжаа олгох, эх хэрэглэгдэхүүнийг баяжуулахад ач холбогдол нь оршино.

Судалгааны арга зүйн хувьд тус судалгааны ажлын хамрах хүрээг өөрийн орны болон олон улсын зэмсэг судлалын түвшин дэх хөгжмийн зэмсгийн ангиллын систем хэмээн тогтоож, судалгааны эх сурвалжуудад тулгуурлан түүхэн материалын арга, төрөл хуваах арга, болон ажиглалт, харьцуулалт, системчлэх, үр дүнг нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн болно.

Хөгжмийн онолч, судлаачдын үзэл баримтлалд тулгуурласан судалгааны үр дүнгээс үзэхэд олон улсын 60-аад оронд тархан нутагшсан ёочин төст зэмсэг нь, ангиллын систем дэх чавхдаст цохивор зэмсгийн төрөлд сантур (*баруун Ази*), долсимер (*Европ*), цымбал (*төв Европ*), янчин (*зүүн, төв Ази*) зэрэг дөрвөн төрөлд ангилагдах бөгөөд “ёочин”-ийн хамрах хүрээ төрөл зүйлийн хувьд зүүн Азийн “янчин”-ны аймагт хамрагддаг байна.

А. Хөгжмийн зэмсгийн ангилал

Салбар дундын шинжлэх ухааны үр дүнгээр тодорхойлогдох, төрөлжүүлэн ангилсан зохион байгуулалт бүхий нийтлэг шинж чанарын ижил төст болон ялгаатай талд тулгуурлан, тэдгээрийг онцлогоор нь өөр хооронд нь харьцуулах, бүлэглэх, нэрлэх, тодорхойлох шинжлэх ухаан бол хөгжмийн зэмсгийн ангиллын систем (*musical instrument classification*) юм.

Зэмсэг судлалын түүхэнд хөгжмийн зэмсгийг урт хугацааны турш газарзүйн болон гарал, уламжлал, хийц-бүтээц, хөгжимдөх үйлээр нь ангилан, системчилж ирсэн байдлаас үзэхэд “чавхдаст”, “үлээвэр”, “цохивор” хэмээх гурван ангилал түгээмэл байдалтай байна. Үүнийг Европын болон Барууны хөгжмийн урлагт “уламжлалт” хэмээн тодотгожээ” [2].

Дундад зуунаас өмнөх үеийн ангиллын талаар Библийн хуучин гэрээ, Эртний грекийн онол, үзэл санаа, Ромын үеийн сурвалж бичигт бичиж тэмдэглэгдсэн байдаг.

Цаашлаад II зууны Грекийн хэл зүйч Поллюксын “*Onomastikon*” хэмээх арван боть бүтээлийн “*De Musica*” хэмээх бүлэгт дундад зууны болон дараах үеийн Европын ангилалд цохивор (*including strings*), үлээвэр (*winds*) гэх хоёр ангилалд хувааж цохивор чавхдастын төрлийг хамтад нь авч үзэж байв. Тэгвэл, гурван талт чавхдаст, үлээвэр, цохивор хэмээх ангилал нь эртний Грек, Ромын хөгжмийн соёлоос үүдэлтэй гэх бөгөөд энэ талаар судлаач Ливен (*F. R. Levin*) бүтээлдээ дурдагджээ [3].

Харин VI зууны Кассидорус (*Cassidorus*)-ын “*Institutiones divinarum et saecularium litterarum*” бүтээлийн тавдугаарт (*De musica*) хөгжмийн зэмсгийн товч жагсаалтыг багтаасан бөгөөд тэрээр цохивор (*metallisch klingende Idiophone*), чавхдаст (*cithara, vermutlich allgemeiner begriff*) болон үлээвэр (*tibia, calami, organa, panduria*) хэмээн ангилжээ.

Ийнхүү Кассидорусын ангиллын систем нь Английн гүн ухаантан Рожер Бекэн (*Roger Bacon*)-ны онолоор XIII зууны үед Европт уламжлагдаж байх үед төв Азид Юань улсын судрын далан нэгдүгээрт тухайн үеийн ордны төрийн ёслолд хэрэглэж байсан “Хуримлах хөгжмийн сав” бүлгийн 29-37 талд хорин нэг зүйл зэмсгийг чавхдаст товшин шудрах, нумт чавхдаст, үлээвэр, цохивор, удирдах-тохиолох зэмсгээс бүрдэнэ. Эдгээр зэмсэг нь хийц бүтцийн хувьд төмөрлөгийн, чулууны, чавхдаст, хулсны, хулын, шорооны, ширийн, модны зэрэг уламжлалт найман аялгууны аймагт ангилагдана хэмээн тэмдэглэгдэж байжээ [4-6].

Дундад зууны сүүл, сэргэн мандалтын үеийн хөгжимдүүрийн ангиллын систем нь XIV зууны эхэн үеийн Парисын онолч Грочео, Германы онолч Вирдунг, Италийн онолч, сэргэн мандалтын үеийн зохиолч Зарлино, Германы XVI, XVII зууны үеийн хэд хэдэн эрдэмтдээс гадна Преториус, Францын суутан Мерсенна нарын бүтээлүүд дээр төвлөрдөг бөгөөд эдгээрээс Вирдунг, Преториус нарын бүтээлүүдийг онцгойлон авч үздэг. Тухайлбал: Вирдуны “*Musica getuscht und angezogen*” (1511) бүтээл [7] нь хөгжимдүүрийн хамгийн эртний хэвлэмэл эх сурвалж, гарын авлага гэдгээрээ алдартай бол Германы сэргэн мандалтын үеийн хөгжмийн зохиолч, онолч Мартин Агриколагийн “*Wayback Machine*”-д архивлагдсан “*Musica instrumentalis deudsch*” бүтээлийг европын зэмсэг судлалын түүхэнд чухал ач холбогдол бүхий анхны томоохон сурвалж бичигт тодотгодог [8].

Энэхүү бүтээлд уламжлалт гурван ангиллыг өргөжүүлэн чавхдаст товшвор (*gitar*), нумт (*хийл*), модон үлээвэр, гуулин үлээвэр гэх мэтээр баяжуулан ангилахдаа хэлбэр дүрс, дуу чимээ гэхээсээ илүүтэй хөгжимдөх үйлээр нь түлхүү тодорхойлжээ.

XVII зуун хүртэл ангиллын системд хүний дуу хоолойг хамруулж байсан бол уламжлалт гурван ангиллыг тухайн үеийн зарим судлаач нь өөр өөрийн үзэл бодолд тулгуурлан нэрлэх, тэмдэглэх, томъёолох нь харилцан адилгүй байв. Тухайлбал: Барууны бусад ангиллын системд хөгжимдүүрийн эгшиглээг цар хүрээгээр нь дуу хоолойн цараа (*Higher-than-sopranino, Sopranino, Alto, Tenor, Baritone, Bass г.м*)-тай адилтган функц (*function, найрал хөгжмийн бүрэлдэхүүнээр*)-ээр ангилж байсан бол улс, үндэстэнд өөр өөрийн үзэл баримтлалд тулгуурлан газар зүйн болон угсаатны гарал үүсэл (*Баруун болон Өмнөд Ази, Зүүн ба Зүүн өмнөд Ази г.м*) зэргээр ангилдаг системийг тодорхойгүй хугацаанд ашигладаг байсан тухай Австралийн угсаатны хөгжим судлаач Маргарет бүтээл [9]-дээ дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Ийнхүү XIX зууны сүүл хүртэл барууны ангиллыг үлээвэр (*wind*), чавхдаст (*strings*) болон цохивор (*percussion*) гэх гурван төрөлд авч үзэж байсан бол Бельгийн хөгжим судлаач Махиллон нь үүнийг эгшиглээ, материаллаг шинж чанараар нь үлээх, чавхдас,

цохивор, цохилгот (*an air column-агаар, салхи; string; membrane-чавхдас, цохивор; and body of the instrument-цохивор*) хэмээн дөрвөн системд ангилсан [10].

Тэгвэл Махиллоны энэхүү системд тулгуурлан Австрийн угсаатны хөгжим судлаач Хорнбостел, Германы хөгжим судлаач Сакс нар ангиллын системийг илүү боловсронгуй болгосноор “Хорнбостел-Саксын систем”-ийг буй болгосон бөгөөд энэ нь эртний болон орчин цагийн уламжлалт сонгодог зэмсгүүдийг "Ziffersystem" буюу "Тоон систем"-д индексжүүлэн шинэчилжээ. Энэхүү ангиллыг тухайн чиглэлийн судалгааны эх сурвалж, хэрэглэгдэхүүн [11]-д онцгой үүрэгтэй чухал ач холбогдолтой систем болсон хэмээн зарим судлаачид онцолдог.

Сакс нь 1914 онд Герман хэл дээр хэвлэгдсэн “Zeitschrift für Ethnologie” хэмээх сэтгүүлд тэд өөрсдийн боловсруулсан шинэчлэл, өөрчлөлтийн тухай хэвлүүлэхдээ энэхүү ангиллыг “Hornbostel-Sachs system” гэж нэрлэжээ.

Энэхүү системийг угсаатны хөгжим, зэмсэг судлаачид өргөн хэрэглэдэг бөгөөд 2011 онд зэмсгүүдийн (*музейн үзмэр*)-ийг шифер, код (*Ziffersystem*)-дыг онлайн (MIMO) болгох төслийн хүрээнд шинэчилсэн баримтжуулсан нь орчин цагийн зэмсэг судлалын чухал баримтад тооцогдох болсон юм. “Hornbostel-Sachs system”-ийн зорилго бол хөгжим судлал, угсаатны хөгжим судлал, угсаатан зүйн цуглуулга, соёлын түүхийн кураторуудад чиглэгдсэн бөгөөд шинжлэх ухааны ангиллын нэг шалгуурыг биелүүлэх замаар шинэ мэдлэг олж авах боломжийг олгодог, онол, практикт тулгуурлан боловсруулагдсан систем хэмээн эрдэмтэд дүгнэсэн байдаг.




Fig.1. Chronology of musical categories

“Хорнбостел-Саксын систем”-ийн зорилго бол хөгжим, угсаатны хөгжим судлал, угсаатан зүйн цуглуулга, соёлын түүхийн зөвлөх, судлаачдад чиглэгдсэн бөгөөд шинжлэх ухааны ангиллын шалгуурыг биелүүлэх замаар шинэ мэдлэг олж авах боломжийг олгодог, онол, практикт тулгуурлан боловсруулагдсан систем юм.

Энэхүү системд, хөгжимдөх үйл (*цохих, татах, товших, үрэх, үлээх г.м*)-ээс гаргах дуу авианы хэлбэлзэлт (*чичрэх, доргих*) хөдөлгөөнийг материаллаг шинж чанараар нь дараах байдлаар төрөлжүүлэн ангилсан байдаг. Үүнд:

1. Idiophones-Цохивор: Цохих явцад гарах аливаа биетийн өөрийн хэлбэлзэл; (*мод, чулуу, төмөр г.м*);
2. Membranophones-Цохивор: Цохих явцад гарах сунган тогтоосон уян биетийн хэлбэлзэл; (*арьс, шир, сарьс, илэг г.м*);
3. Chordophones-Чавхдаст: Цохих, товших, үрэх явцад гарах чавхдасны хэлбэлзэл; (*гэдэс, өлөн, торго, ган, зэс г.м*);
4. Aerophones-Үлээвэр: Үлээх явцад гарах агаарын урсгал, орон зайн хэлбэлзэл (*мод, төмөр, гууль, хулс г.м*) зэрэг болно [12].

Энэхүү систем нь олон жилийн турш судлаач, шүүмжлэгч нарын шүүмжлэлд нэлээдгүй өртдөг ч орчин цагийн онолч, судлаачид улам боловсронгуй болгох зорилгын дор өөр өөрийн үзэл бодлоо илэрхийлж, санал дэвшүүлсээр ирсэн. Тухайлбал: Францын угсаатны хөгжим судлаач Шеффнер (*André Schaeffner*) нь 1932 онд Ром тоогоор тэмдэглэсэн хоёр ангиллыг дэвшүүлсэн байдаг [13].

Table 1. Three traditional Western categories of names

Category	Type	Explanation
I: instruments that make sound from vibrating solids	I.A: no tension	xylophones, cymbals, or claves
	I.B: linguaphones (<i>lamellophones</i>)	solid fixed at only one end, such as a kalimba or thumb piano
	I.C: chordophones	solid fixed at both ends, i.e. strings such as piano or harp; plus drums
II: instruments that make sound from vibrating air	I.A: Membranophones	such as clarinets, trumpets, or bull-roarers.

Уг систем нь хордофоны хувьд Mahillon болон Hornbostel-Sachs-тай санал нийлдэг ч цохиворын ангиллыг харилцан адилгүй бүлэглэсэн бол 1960 онд Германы хөгжим судлаач Рейнхард (*Kurt Reinhard*) морфологиос ялгаатай нь дан болон олон хоолойгоор тодорхойлогддог хоёр ангилал зүйг гаргахдаа дууны давтамжийн өөрчлөлтөөр 12 бүлэгт хуваан ангилжээ.

Канадын зохион бүтээгч Манн (*Steve Mann*) нь: Шеффнерийн санал болгосон ангилалд тулгуурлан физикт суурилсан таван ангиллын танилцуулсан байдаг. Энэхүү систем нь *gaiaphones* (*chordophones, membranophones, болон idiophones*), *hydraulophones*, *aerophones*, *plasmaphones*, болон *quinterphones* (*цахилгаан болон оптикийн аргаар үйлдвэрлэсэн хөгжим*)-ээс бүрдэх бөгөөд энэ нь дэлхий, ус, салхи, гал, шороо зэрэг таван мөн чанарыг илэрхийлсэн байна. Ингэснээр Шеффнерийн ангилал зүйд гурван шинэ ангиллыг нэмж оруулсан байна [14].

Table 2. Musical instrument classification in physics-based organology

№	Element	State	Category	Explanation
1	Earth	solids	gaiaphones	the first category proposed by Andre Schaeffner
2	Water	liquids	hydraulophones	
3	Air	gases	aerophones	the second category proposed by Andre Schaeffner
4	Fire	plasmas	plasmaphones	
5	Quintessence/Idea	informatics	quintephones	

Харин манай зэмсэг судлалын түвшинд зохиолч Ч. Лодойдамба “Монголын хөгжмийн соёлын тухай товч” бүтээлдээ “... Монгол ардын дуу тогтвортой аялгууны эргэлтээр онцгой бөгөөд Монгол хөгжмийн зэмсэг нэн олон төрөл боловч түүний онцлог хэдэн бүлэг болгож үзэх нөхцөл буй” хэмээгээд **чавхдаст хөгжим, шудрах хөгжим, дэлдэх утсан хөгжим, дэлдэх хөгжим, үлээвэр** хэмээх таван ангиллыг тогтоож “... Эл хөгжмийн зэмсэг цөм таван дуут тогтолцоонд тохирч байна” гэж тэмдэглэсэн [15] байхад, урлаг судлаач Ж. Чулуунцэцэг “Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг судлал” бүтээлдээ Монголын “Төрийн их найрал”-ын бүрэлдэхүүнийг **чавхдаст, үлээвэр, дэлдэх** хэмээн ангилж нэр, нэршлийг боловсронгуй болгон зэмсгийн төрөл зүйлийг баяжуулахын зэрэгцээ зэмсэгтэй харьцах үйл хөгжимдөх арга, таван эгшгийн шүтэлцээний онцлогт тулгуурлан авч үзсэн байна [16].

Ийнхүү ангиллын системийг тодорхойлох судлаачдын үзэл бодол урт хугацааны турш өөрчлөгдөн шинэчлэгдэж тухайн системийг улам боловсронгуй болгох, системчлэх томъёолох эх үйлс нь зэмсэг судлалын судлагдахуунд үнэтэй хувь нэмэр, ач холбогдол бүхий чухал хэрэглэгдэхүүн болсоор байна.

Б. Чавхдаст хөгжимдүүрийн ангилал, төрөл зүйлс

Чавхдастын ангиллын системд урт хугацааны турш “Rhythmic”, “unfretted (*open*) stringed”, “bowed stringed”, “vibrating strings”, “stick-struck”, “Stringed String”, “Percussion, String” гэх мэт олон янзаар нэрлэсээр ирсэн ч орчин цагт “Хорнбостел-Саксын систем”-д “хордофон”-ны ангилалд төвлөрөх болж, илүү боловсронгуй, нарийвчлалтай, тодорхойлогдон системчлэгджээ.




Fig.2. String instruments in the Hornbostel–Sachs system.

Чавхдаст цохивор зэмсгийн “Хорнбостел-Саксын систем” дэх ангиллыг дэлгэрэнгүй задлан шинжиж үзэхэд, “chordophones буюу чавхдаст”-ын төрлийг тухайн систем нь хэлбэр дүрс, чавхдасны тоо ширхэг, эгшиглээний онцлогоор нь “луте” (*lyre*), “харп” (*harp*), “луте” (*lute*), “зитер” (*zither*) хэмээн дөрөв бүлэглэн ангилжээ.

Чавхдаст цохиворын зэмсэг нь дээрх ангиллын чавхдастын нэг болох “Зитер”-ийн төрөлд хамрагдах бөгөөд уг төрлийг физик шинж чанар (*цуурайт*)-аар нь 311-316 тоотод дугаарлан зургаа ангилжээ [17].

Table 3. Classification of stringed instruments

№	Nomenclature	Figure	Location	Chronology
1	Bar -311 (нуман хэлбэрт)		Swaziland, Africa, Madagascar, Réunion	13000 BC
2	Tube-312 (гуурсан биет)		Madagascar, India, Southeast, Asia, Taiwan	7000-10000 BC
3	Raft-313 (хавтгай биет)		Congo, Other African, Nigeria, East Africa	not clear
4	Board-314 (хөндий хавтгай биет)		North and South America, Europe and the southern regions of Germany	1600 BC
5	Trough-315 (хотгор биет)		East and Central Africa, mainly Rwanda and Burundi	not clear
6	Frame-316 (хулуун чавхдаст)		Africa (<i>Nuba people of Sudan</i>)	not clear

Тэгвэл чавхдасыг цохин хөгжимдөх үйлийн зэмсгийг чавхдастыг 314 тоотод ангилан “Board” буюу хавтгай, “With resonator” буюу цуурайт, “With resonator box” буюу хөндий, “Percussion-Stringed” буюу чавхдаст цохиворын ангилалд төрөлжүүлжээ [18].

Table 4. Classification of stringed percussion instruments

Nomenclature	Location	Number	Description
Cimbalom, cymbalom, cymbalom, cymbalum, şambal, tsymbaly, tsimb l, santouri, santur	Hungary	314. 122-4	Chromatic hammered dulcimer
kokles: kokle, kūkles, kūkļas, kūkļes, kūklis, kūkļis, kūkle, kūkļe, kūkla and kūkļa (in Latgale)	Latvia and Latvian-Americans	314. 122-5	Diatonic, lute-like string instrument
Santur	Iran	314. 122-4	A trapezoidal stringed percussion instrument with 72 strings and two rows of frets.
yangqin: yang ch'in, yang qin	China		A brass stringed percussion instrument with a trapezoidal shape and a hollow body (<i>pentatonic</i>)
Y"oochin	Mongolia		
Yanggeum	Korea		

Ийнхүү “Хорнбостел-Саксын систем” дэх чавхдастын төрөл болох ёочин төст зэмсгүүд нь урт хугацааны турш уламжлагдах явцдаа түүний хувьсан өөрчлөгдөх шинж чанар, төрөл зүйл нь тархац нутгийн хувьд өөр хоорондоо харилцан адилгүй хөгжиж ирсэн бөгөөд үүнийг бид чухалчлан авч үзэх нь түүний нийтлэг шинж чанарын ижил төст болон ялгаатай талд тулгуурлан онцлогийг тодруулахад ач холбогдол нь оршдог.

Чавхдаст цохивор ижил төст олон арван зэмсгүүд нь орчин цагийн төгөлдөр хуурын өвөг хэмээх тодотголтой дөрвөлжин, зууван, трапец хэлбэрт, цохих үйлээр эгшиглэх чавхдаст цохивор ёочин төст хөгжимдүүр юм. Эндгээр нь дэлхийн олон улс оронд уламжлагдан нутагших явцдаа түүхэн хувьсал, газар зүйн байршил, хийц-бүтээц, хөг эгшиглэгээ, эгшиглээний онцлог, нэр нэршил, хөгжимдөх арга барилаараа сантур (*santur*), долсимер (*dulcimer*), цимбал (*cimbalom*), янчин (*yang-qin*) гэх дөрвөн хөгжимдүүрээс улбаатай юм.

Table 5. Types and names of stringed percussion instruments

Santur/сантур	Tsymbaly/цымбал	Dulcimer/долсимер	Yangqin/янчин
santūr, Santoor, Santour: Iran (سنتور), Afghanistan, Armenia, Turkey, Pakistan, Iraq, India	Tsymbalyor dulcimer: (Дульцимер) in Russia Tsymbaly in Belarus and Ukraine (цимбали), Cymbaly Moldova, and Poland Tsimbal in Serbia Tsimbl in Yiddish communities Cimbalom, cimbalom,	Hammered dulcimer in England, United Kingdom, United States, Whamdiddle, Whamdi dle, Lumberjack Piano in Early North America	yángqín, yang qin, or yang ch'in (扬琴 from 揚琴) in China and Tibet; also a silk-strung version hudie qin (蝴蝶琴) Chang in Uzbekistan
		Hackbrett	

Salterio: Italy, Spain (dulcémele), Mexico Saltério: Brazil (Brasil) and Portugal Santoor, sandouri, santour: (σαντούρι) Greece	cymbalum, țambalin Hungary (Magyarország) Cimbal in Slovakia Țambal in Romania Tiompan (Scottish Gaelic) or tiompán (Irish) in Scotland and Ireland Psaltérion and tympanon in France Cimbal, cimbale in Croatia Cimbál in Czech Republic Cimbalai, cimbolai in Lithuania Cymbal, cimbole in Latvia (Latgalia) Cimbale, oprekelj in Slovenia	Hackbrett Austria (Osterreich), Switzerland (Schweitzer) Bavaria (Bayern, in southern Germany) Hakkebord in Belgium Hakkebræt in Denmark (Danmark) Hakkebord in the Netherlands Hakkebrett in Norway Hackbråde, hammarh ara in Sweden	Yanggeum 양금 in Korea Yoochin in Mongolia Khim (கிம்) in Thailand, Cambodia and Laos Tam-thap-luk or dân tam thập lục in Vietnam Darushimaa ダルシマ — in Japan דולצימר פטישם in Israel
---	---	--	---

Ёочин төст зэмсгүүд нь үүссэн он тоолол, газар зүйн бүс нутаг, нэр нэршил, хийц-бүтээц, эгшиглээ, эгшиглэгээ зэрэг нь шинж чанараараа харилцан адилгүй ч хэлбэр дүрсийн хувьд трапец болон хоёр цохиураар цохин хөгжимдөх үйл нь нийтлэг бөгөөд бид эдгээр ижил болоод ондоолог шинж чанарыг дараах байдлаар товчхон авч үзэв. Үүнд:

Сантур: Ёочин төст зэмсгийн эртний шинж чанарыг хадгалсан гэх тодотголтой сантур нь тархац нутгийн хувьд баруун Азийн бүс нутгийн Иран, Афганистан, Армен, Турк, Пакистан, Ирак, Энэтхэг гэх мэт улс орнуудад тархан нутагшсан бөгөөд хийц-бүтээцийн хувьд нутаг нутгийн онцлогоор өөр хоорондоо харилцан адилгүй уламжлагдан, хөгжлийн явцад Перс, Энэтхэг сантур хэмээх хоёр хэлбэрт хэлбэржиж ирсэн байдаг.

Долсимер: Төгөлдөр хуурын өв гэх тодотголтой долсимерын төрөл зүйлийг товчхон авч үзэхэд, тархац нутгийн хувьд Баруун Европ, Хойд Америкийн нэгдсэн улс, Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад ихэвчлэн нутагшсан бөгөөд өөр хоорондоо хийц бүтцийн хувьд харилцан адилгүй уламжлагдан ирсэн.









Европ долсимер нь ёочин төст зэмсгийн шинжийг бүхэлд нь агуулах бөгөөд хувьслын явцдаа тодорхой стандартаар загварчлагдаагүй, урлаачдын бүтээлч ухаан, ур чадвараас шалтгаалан олон хувилбар, хийц бүтцээр уламжлагдсаар иржээ.

Цымбал: Цымбалын гарвэлийг цыганы хөгжмийн соёлтой холбон авч үздэг. Учир нь, Цыганы нүүдэл нь Унгарт тухайн зэмсэг нутагшихад чухал нөлөө үзүүлсэн. Улмаар цымбал нь Унгарт нутагшихдаа эртнээс уламжлагдан ирсэн “ард”-ын, төгөлдөр хуурын бүтцэд тулгуурлан илүү боловсронгуй хувилбарт бүтээгдэн шинэчлэгдэн “концерт”-ын хэмээх хоёр төрөлд уламжлагдан хөгжсөн.

“Ард”-ын гэх тодотголтой жижиг хэлбэрийн цымбал нь Беларус, Украин (*Tsymbaly*), Молдова болон Польш (*cymbaly*), Румын (*Țambal*), Словак (*Cimbal*) гэх мэт олон улс оронд өөр өөрийн онцлогоор тархсан.

Янчин: Янчин нь төв болон зүүн Азийн бүс нутагт Хятад (揚琴), Солонгос (*yanggeum*), Тайланд болон Лаос (*khim-ຊົມ*), Вьетнам (*tam-thap-luk* or *đàn tam thập lục*), Япон (*darushimaa* ダルシマー), Монгол (*y"oochin*), Буриад гэх мэт улс оронд нутагшин хийц-бүтээцийн хувьд өөр өөрийн онцлог (*технологи, маитаб*)-оор уламжлагдан иржээ. Хөгжлийн явцад Хятадын үе үеийн урлаачид түүний хийц бүтцийг олон хувилбарт урлан туршиж, хэрэгжүүлж, шинэчлэн боловсруулж, мастер хувилбаруудыг гаргаж ирсэн билээ.

Table 6. A yochin-like musical instrument

№	Nomenclature	Features	Picture	Location	Chronology
1	Santur			West Asia	669 BC
2	Dolsimer			Northern Europe	605/604-562 BC
3	Cimbalom			Western Europe	XIII-XIX centuries
4	Yangqin			Central Asia	XV century

Ийнхүү эртний нэг чавхдаст хөгжмийн хэрэгслээс 150 орчим чавхдаст цохивор зэмсэгт биеллээ олон хувьссан олон арван ижил төст ёочин нь дэлхийн олон улс оронд тархах явцад түүхэн хувьсал, газар зүйн байршил, хийц бүтэц, хөг эгшиглэгээ, эгшиглээний онцлог, нэр нэршил, хөгжимдөх арга барилаараа өөр хоорондоо харилцан адилгүй нутагшиж ирсэн байдаг.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд, хөгжмийн эгшиг дуурьсгах хэрэглүүр буюу зэмсгийг II зууны үеэс ангилж, төрөлжүүлж эхэлсэн гэх бөгөөд угтаа VI зуунаас XX зууныг хүртэл үлээвэр, чавхдаст, цохивор хэмээх уламжлалт гурван ангилалд тулгуурлан үе үеийн онолч, судлаачдын илүү дэлгэрэнгүй нарийвчлан төрөлжүүлсээр ирсэн.

Тэгвэл, бид чавхдасны хэлбэлзэл, зэмсгийн эгшиглээ, хийц бүтцийг физик шинж чанараар нь бусдаас илүү боловсронгуй түвшинд ангилсан “Хорнбостел-Саксын систем”-ийн чавхдастын төрлийг судалгааныхаа хамрах хүрээ болгон авч үзэхэд, чавхдаст цохивор зэмсгийг “Зитер”-ийн төрөлд хамруулахдаа дараах байдлаар ангилан төрөлжүүлжээ. Үүнд:

- I. Хэлбэр дүрсээр: Хавтгай-314 (*Board*)
- II. Физик шинж чанараар: Цуурайт-314.12 (*With resonator*)
- III. Хийц бүтцээр: Хөндий биет (*With resonator box*)-314.122
- IV. Хөгжимдөх үйлээр: Чавхдаст цохивор (*Percussion-Stringed*)-314.122.4 зэрэг болно.

Чавхдаст цохивор зэмсэг нь хөгжимдөх үйлээрээ дараах хоёр төрөлд ангилагддаг. Үүнд:

- ✓ Даруулт (*clavicymbalum, clavichord, harpsichord* г.м),
- ✓ Цохивор (*psaltery, hakkbred, santur, yangqin* г.м) зэрэг болно.

Энэхүү системд, чавхдаст цохивор төрөлд Монголын уламжлалт ёочинг төрөлжүүлэн авч үзлээ.

Зүүн Азийн янчины аймагт хамрагдах ёочин нь манай үндэсний хөгжмийн урлагт “дэлдэх чавхдаст зэмсэг” хэмээн тодорхойлогдсон байдаг. Харин олон улсын ангиллын систем дэх ёочингийн төлөв байдал, байр суурийг бид дээрх судалгаагаар чавхдаст цохивор гэж тодорхойлон нотолж, танин мэдэхгүйн түвшинд мэдээллийг боловсруулан судалгааны эргэлтэд оруулсанд бидний энэ удаагийн судалгаа үр дүн, ач холбогдол нь оршино.

НОМ ЗҮЙ

1. Hornbostel, M.von., Sachs, C. (1959). *Systematik der Musikinstrumente. Ein Versuch 1914 by Erich M. von Hornbostel, Curt Sachs*. New York, Germany: In: Zeitschrift für Ethnologie. Band 46, 1914, Nr. 4–5, S. p. 553–590.
2. Kartomi, M J. (1990). *On Concepts and Classifications of Musical Instruments*. United States:: Chicago Studies in Ethnomusicology. University of Chicago Press.
3. Levin, F. R. (1975). *Greek reflections on the nature of music*. The harmonics of Nicomachus and the Pythagorean tradition: American Philological Association.
4. Оюунчимэг, Л. (2005). *Шударгын 18 ая хөг*. Улаанбаатар, Монгол улс: Содпресс. Х.16
5. Чулуунцэцэг, Ж. (2008). *Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг судлал*. Улаанбаатар, Монгол улс: Арт софт.
6. Соронзонболд, С. (2013). *Монгол хөгжим. Юань улсын ордны хөгжим, бүжиг, жүжиг, хувцас*. Улаанбаатар, Монгол улс: MigmaPrint.
7. Virdung, S. (1511). *Musica getutsch A Treatise on musical instruments*. Cambridge: CUP, 1993: Trans. and ed. Bullard Beth. United Kingdom.
8. Agricola, M. (1529). *Musica instrumentalis deudsch*. Wittenberg: Facs. edn: Published along with Ein kurtz deutsche Musica [Wittenberg: 1528] and Musica figuralis deudsch, [Wittenberg: 1532J], Hildesheim: 1969.
9. Kartomi, M J. (1990). *On concepts and classifications of musical instruments*. Chicago, United States: University of Chicago Press.
10. Mahillon, V. Ch (1880). *Catalogue Descriptif & Analytique du Musée Instrumental du Conservatoire Royal de Bruxelles*. Belgian: Gand: C. Annoot-Braeckman.
11. Hornbostel, M.von., Sachs, C. (1959). *Systematik der Musikinstrumente. Ein Versuch 1914 by Erich M. von Hornbostel, Curt Sachs*. New York, Germany: In: Zeitschrift für Ethnologie. Band 46, 1914.
12. Hornbostel, M.von., Sachs, C. (1914). *Systematik der Musikinstrumente: Ein Versuch*. Berlin, Germany: Zeitschrift für Ethnologie: Organ der Berliner Gesellschaft für Anthropologie, Ethnologie und Urgeschichte 46.
13. Kartomi, M J. (1990). *On Concepts and Classifications of Musical Instruments*. Chicago Studies in Ethnomusicology: University of Chicago Press.

14. Mann, S. (2007). *Natural Interfaces for Musical Expression, Proceedings of the Conference on Interfaces for Musical Expression*. New Interfaces for Musical Expression. p. 23-118
15. Лодойдамба, Ч. (1965). *Монголын хөгжмийн соёлын тухай товч*. Улаанбаатар: Цог сэтгүүл - №1.
16. Чулуунцэцэг, Ж. (2008). *Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг судлал*. Улаанбаатар, Монгол улс: Арт софт. X.9
17. Hornbostel, M.von., Sachs, C. (1961). *Classification of Musical Instruments*. United Kingdom: The Galpin Society Journal, Vol. 14. 14. p. 3-29
18. Cristina Ghirardini. (2015). *Refecting on Hornbostel-Sachs 's Versuch a century later*. Venezia. (2020). Edizioni Fondazione Levi. p. 256

ANALYSIS OF YOCHING IN MUSICAL INSTRUMENT CLASSIFICATION SYSTEM

Uranbileg Samdansuren*, Ts.Tsevegsuren (Ph.D)

Department of Traditional Art, University of Culture and Arts, Ulaanbaatar, Mongolia

*E-mail: hui4@yahoo.com
ORCID: 0009-0008-2914-8945

Received: 20.12.2023

Revised: 02.03.2024

Accepted: 24.04.2024

Abstract

Analyzing the types of stringed percussion instruments based on the music classification system from the 6th century to the 20th century is important for clarifying the position, state, and types of yoching at the level of international organology. In the history of musical instruments, they have long been systematized in many ways based on geography, origin, tradition, structure, and musical performance. According to the generalization, three categories: "strings," "winds," and "percussion" are popular. Musicologists and theorists have elaborated and systematised These three traditional categories in various ways throughout history.

In this system, stringed instruments are divided into four categories based on shape and timbre: lyre, lute, harp, and zither. Stringed musical instruments were also divided into four categories based on their structure, physical characteristics, and musical performance and included in the "zither" category.

This time, we are particularly considering the "Hornbostel-Sachs system" indexed and encoded in the numerical system of the Austrian ethnomusicologist Hornbostel and the German musicologist Sax in the 19th century. According to our research, the yochin belongs to the board zither type of instrument within the six types of instruments in the zither category: bar, tube, raft, board, trough, frame, or board zither.

Keywords: Instruments, categories, classification, traditions, reformations, forms, design structure, sounds, strings



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)